



# Хурлын материал 2026

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурал

2026.04.28

# Гарчиг

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал:

## Танилцах асуудал

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

## Хэлэлцэх асуудал

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
  3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
  8. Саналын хуудасны загвар

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

### "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3

Хурал болох газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах Монголын хөрөнгийн биржийн төв байрны 1 давхарт байрлах хурлын танхимд

Хурал болох өдөр, цаг: 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт

Хурал болох хэлбэр: хосолсон (танхим болон зайнаас)

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

#### Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.

#### Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан;
4. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
6. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл
10. Шаардлагатай бусад материал.

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

Хувьцаа эзэмшигч Та 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл ([www.mse.mn](http://www.mse.mn)) цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байр Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3;
- Хурал зохион байгуулах комиссын утас: 11-313747, цахим шуудан (shareholders@mse.mn)

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд ирж, эсхүл цахим хэлбэрээр "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудас ([www.mse.mn](http://www.mse.mn))-аар өгөх боломжтой ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 17:30 цаг байна.

~o0o~

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4, 4.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах Монголын хөрөнгийн биржийн төв байрны 1 давхарт байрлах хурлын танхимд хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх зөхирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралт, хурлын зарын загварыг Хоёрдугаар хавсралт, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Гуравдугаар хавсралт, саналын хуудасны загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

1526010023

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг Тавдугаар хавсралт, хурлын тооллогын комиссыг Зургаадугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдэлд тавигдах шаардлагыг Долоодугаар хавсралтаар баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой программ хангамжийн бэлтгэл ажлыг хангахыг гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 17:30 цаг хүртэл хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд цаасан болон цахим хэлбэрээр ([www.mse.mn](http://www.mse.mn)) урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Д.Мөнхбат)-т даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисст даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-ыг томилсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад шаардлагатай материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зөх зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 03 сарын 18-ны өдрийн 09 дүгээр  
тогтоолын Зургаадугаар хавсралт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга: Б.Онон ("БиДиСек ҮЦК" ХК-ийн Институционал харилцагчийн албаны захирал)

Комиссын гишүүд: Э.Пүрэвжаргал ("БиДиСек ҮЦК" ХК-ийн Институционал харилцагчийн албаны ахлах мэргэжилтэн)

Г.Анхбаяр ("БиДиСек ҮЦК" ХК-ийн Институционал Харилцагчийн албаны иргэжилтэн)

~oOo~

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр

### ХУГАЦАА

### ХӨТӨЛБӨР

09:30-10:00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх <i>Хурал зохион байгуулах комисс</i>
10:00-10:05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах <i>Тооллогын комисс</i>
10:05-10:10	Хурлын үйл ажиллагааг нээж үг хэлэх <i>Хурлын дарга</i>
10:10-10:15	Хурлын дэгийг танилцуулах <i>Хурлын дарга</i>
10:15-10:40	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах <i>Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч</i>
10:40-10:50	Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах; <i>Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч</i>
10:50-11:20	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах <i>Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч</i>
11:20-11:30	Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх талаарх видео зааврыг танилцуулах <i>Тооллогын комисс</i>
11:30-11:55	Асуулт, хариулт <i>Асуулт 2 минут, Хариулт 2 минут</i>
11:55-12:10	Санал хураалт, санал тоолох <i>Тооллогын комисс</i>
12:10-12:15	Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах <i>Тооллогын комисс</i>
12:15-12:20	Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулж, хурлыг хааж үг хэлэх <i>Хурлын дарга</i>

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн (цаашид "МХБ" гэх) Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-ийн холбогдох журам, заавар, компанийн дүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна.

### Хоёр. Хурлын дарга, түүний эрх, үүрэг

- 2.1. Хурлын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын даргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.
- 2.2. Хурлын дарга дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
  - 2.2.1. Хурлыг нээж, хуралд оролцогчдод дэгийг танилцуулах;
  - 2.2.2. Хуралд оролцогчдод асуулт асуух зөвшөөрөл олгох;
  - 2.2.3. Хурлыг дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос дэгийг сахин биелүүлэхийг шаардах.Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох эрхтэй;
  - 2.2.4. Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгох.

### Гурав. Хуралд оролцох

- 3.1. Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 30 минутын өмнө хуралд оролцох бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.
- 3.2. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь цахимаар хуралд оролцохдоо өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхийг, итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг цахим системд бүртгүүлнэ. Энэхүү итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй байна.
- 3.3. Хуралд оролцогч МХБ-ийн хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь цахим хэлбэрээр хуралд оролцохдоо өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувилбар/-г системд оруулна. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг гэрчилгээний хамт системд оруулна.
- 3.4. Хуралд оролцогчийг дараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын системээс хасна. Үүнд:
  - 3.4.1. хувьцаа эзэмшигч биш байх;
  - 3.4.2. хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримт бүртгүүлээгүй байх;
  - 3.4.3. хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх;
  - 3.4.4. цахим хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох;
  - 3.4.5. хурлын даргын сануулгыг удаа дараа зөрчих;
  - 3.4.6. ёс бус үг хэллэг хэрэглэх.

### Дөрөв. Асуулт, хариулт

- 4.1. Хуралд оролцогчдын асуулт, хариулт нь хэлэлцэх асуудалтай шууд холбоотой товч, тодорхой байна.
- 4.2. Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3. Асуулт асуух оролцогч нь гараа өргөж хурал зохион байгуулагчид мэдэгдэнэ.
- 4.4. Хурал зохион байгуулагч нь асуулт асуух хувьцаа эзэмшигчдийг цаг, хугацааны дарааллын дагуу овог, нэр, асуултыг хурлын даргад танилцуулна.
- 4.5. Асуултад компанийн эрх бүхий албан тушаалтан хариулна.
- 4.6. Асуултад хариулах этгээд нь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуултад хариулахаас татгалзах эрхтэй.
- 4.7. Асуултыг хурлын системээр дамжуулан comment, chat хэлбэрээр асууж болно.

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

- 4.8. Асуулт асуух, асуултад хариулах хугацаа хоёр минутаас илүүгүй байна.
- 4.9. Асуулт асуух хугацаа хэтэрсэн тохиолдолд хурлын дарга хугацаа дууссаныг сануулах бөгөөд сануулснаас хойш 30 секунд өнгөрмөгц хурлын дарга тухайн хүнийг асуултаа дуусгахыг шаардана
- 4.10. Хурлын дарга тодорхой асуудлаар шаардлагатай гэж үзвэл асуултад хариулах хугацааг хэдэн ч удаас сунгаж болно.
- 4.11. Асуултад хариулж дууссаны дараа хурал зохион байгуулах комисс асуултуудыг цаасан болон цахим хэлбэрээр цуглуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

### Тав. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх

- 5.1. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах албан ёсны зард тусгагдсан бүртгэлийн өдрөөс эхлэн урьдчилсан санал өгч болно.
- 5.2. Урьдчилсан санал гэдэг нь хувьцаа эзэмшигчийн хурлын товлосон өдрөөс өмнө батлагдсан саналын хуудсаар болон цахим хэлбэрээр өгсөн хувьцаа эзэмшигчийн санал байна.
- 5.3. Урьдчилсан санал өгсөн тохиолдолд түүнийг дахин өөрчлөхгүй ба тус санал нь эцсийнх байна.
- 5.4. Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр өөр агуулгатай санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түрүүлж өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 5.5. Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотойгоор нэг санал өгөх эрхтэй.
- 5.6. Хуралд оролцогч хурлын өмнө санал өгөх цахим заавартай танилцсан байх бөгөөд тус зааврын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйд тооцно.
- 5.7. Хэлэлцэх асуудлаар санал өгөхдөө [hural.mse.mn](http://hural.mse.mn) сайтын нэвтрэх хэсгийн НЭР гэх цонхонд өөрийн утасны дугаарыг, НУУЦ ҮГ гэх цонхонд утасны дугаарт ирсэн нууц үгийг оруулж нэвтэрнэ.
- 5.8. Нэвтэрсний дараа хурлаар хэлэлцэж буй асуудлын харалдаа байрлах “ЗӨВШӨӨРСӨН”, “ТАТГАЛЗСАН”, “ТҮДГЭЛЗСЭН” хэсгээс сонгон саналаа тэмдэглэн оруулна.
- 5.9. Саналыг зөвхөн нэг удаа өгөх тул сайтар нягталж шалгасны дараа санал өгөх товчийг дарж саналаа илгээнэ.

### Зургаа. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах

- 6.1. Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд тусгагдсан тооллогын комисс цахим программ нэгтгэсэн тайланг тэмдэглэн авна.
- 6.2. Тооллогын комиссын дарга нь нэгтгэгдсэн саналыг хурлын даргад танилцуулна.
- 6.3. Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийг тус хуралд оролцсонд тооцож бүртгэнэ.
- 6.4. Тооллогын комисс нь цаасан хэлбэрээр өгсөн хүчин төгөлдөр саналыг цахим систем рүү оруулж, саналыг нэгтгэнэ.
- 6.5. Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан болон цаасан хэлбэрээр өгсөн санал /хүчин төгөлдөр болон хүчин төгөлдөр бус/-ыг хамтад нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт компанийн архивд хадгалуулна.

### Долоо. Хариуцлага

- 7.1. Хуралд оролцогч хурлын үед дэг зөрчсөн, бусдыг доромжилсон бол хурал дарга дараах хариуцлагыг хүлээлгэнэ. Үүнд:
- 7.1.1. дэг баримтлахыг нэр заан шаардах;
- 7.1.2. сануулга өгөх;
- 7.1.3. урьдчилан сануулга авсан хуралд оролцогчийг дахин зөрчил гаргавал түүнийг тухайн өдрийн хурлын системээс хасах;
- 7.2. Энэхүү дэг нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал дуусгавар болсноор хүчингүй болно.

~oOo~

## Танилцах асуудал

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга




2023 ОН	2024 ОН	2025 ОН
<b>ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ</b>		
11.6 их наяд	13.0 их наяд	<b>13.85 их наяд</b>
<b>ТОП-20 ИНДЕКС</b>		
41,437.42 нэгж	51,675.71 нэгж	<b>54,478.17 нэгж</b>
<b>БҮТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ТОО</b>		
173 ХК	172 ХК	<b>162 ХК</b>
<b>ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА</b>		
33.3 ТЭРБУМ	45.15 ТЭРБУМ	<b>33.43 ТЭРБУМ</b>

### ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 25.12 сая ширхэг үнэт цаас нийт 7.48 тэрбум төгрөгөөр арилжигдлаа. Компанийн зах зээлийн үнэлгээ 2025 оны эцэст 109 тэрбум 358 сая төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээгээр 17-р байрт эрэмбэлэгдлээ.

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК 9000 ГАРУЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАВ.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор 2024 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 47 төгрөгөөр тооцон, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан татварын дараах 5,315,705,427.90 төгрөгийг 9,635 хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулж, компанийн 66% эзэмшигч Сангийн яам буюу улсын төсөвт 10,871,378,992.00 төгрөгийн ногдол ашгийг тус тус шилжүүллээ.



## Танилцах асуудал - Төлөөлөн удирдах зөвлөлийн танилцуулга

### Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй.

Компанийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2023-2027 оны стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна.

ТУЗ-ийн үүргийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрэм болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д тодорхой заасан байдаг.

### ТУЗ-ийн хороод

ТУЗ нь дэргэдээ тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэгтэй.

Хороодын үйл ажиллагааг "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүд нь нэгээс доошгүй хороонд орж ажилладаг бөгөөд хорооны нийт гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдэж байна.

### Аудитын хорооны бүрэлдэхүүн

Н. Улаанхүү	Хорооны дарга
Р. Мөнхтөр	Гишүүн
Ж. Цогтбаяр	Гишүүн

### Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Р. Мөнхтөр	Хорооны дарга
Н. Улаанхүү	Гишүүн
С. Баянцогт	Гишүүн

### Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Н. Отгончимэг	Хорооны дарга
М. Банзрагч	Гишүүн
Т. Ганбаатар	Гишүүн

### Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

М. Банзрагч	Хорооны дарга
Н. Отгончимэг	Гишүүн
Ж. Бямбасүрэн	Гишүүн

### ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх.

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар, туршлага нь МХБ-ийн үйл ажиллагааны стратеги зорилго, зорилт, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг хийж ажилладаг.

### ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон 3 жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2023 оны 6-р сарын 30-ны өдрөөс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар дээрх гишүүдийг сонгож 3-н жилийн хугацаатай томилсон.

### ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог. 2025 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөгдөөгүй.

## Танилцах асуудал


### ➔ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасны дагуу 5 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүдээс бүрддэг.


2023 оны 6-р сарын 30-ны өдрөөс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар ТУЗ-ийн гишүүдийг сонгож 3-н жилийн хугацаатай томилсон.

ТУЗ-ийн нийт гишүүдийн 22% нь эмэгтэй гишүүд ба гишүүдийн насны бүтэц, ажилласан жилийг дараах байдлаар үзүүллээ.

#### Гишүүдийн нас



#### Гишүүнээр ажилласан хугацаа



### ➔ ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Компанийн тухай хууль"-ийн 75.9 дэх зүйлд заасны дагуу МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2023 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн бүх гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2025 онд ТУЗ нийт 15 удаа хуралдсан. ТУЗ-ийн хурлаар нийт 69 асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 61 тогтоол гаргаж, 8 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн 15 удаагийн хурал Улаанбаатар хотод МХБ-ийн хурлын танхим болон цахим хосолсон хэлбэрээр явагдсан байна.

#### ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч ердийн гишүүдэд цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын дагуу тогтоодог ба гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

#### ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

1	ТУЗ-ийн дарга	1,584,000₮
2	Ердийн гишүүд	1,584,000₮
3	Хараат бус гишүүд	1,584,000₮
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1,600,000₮

1 сарын цалин хөлс, ₮

## Танилцах асуудал - Хяналтын зөвлөлийн танилцуулга

### Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

"Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн дүрэм болон хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс компанийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэгтэй. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хуулийн дагуу хамгаалах чиглэлээр санал гаргаж ТУЗ-д хүргүүлэх,

- Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж гаргаж ТУЗ-д хүргүүлэх,

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвлөмж гаргаж компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэх.

### Хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрээр томилогдсон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

### Цалин урамшуулал

Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг. Зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог ба зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар тогтоолоор зөвлөлийн гишүүний цалинг тухайн сард хуралдсан эсэхээс хамааруулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосон. Хяналтын зөвлөлийн гишүүдэд олгосон цалин хөлсийг дараах хүснэгтээр харуулав.

### Цалин урамшуулал

1 сарын цалин хөлс, ₮

Хяналтын зөвлөлийн дарга	1,584,000
Хяналтын зөвлөлийн гишүүд	1,584,000

### Хяналтын зөвлөлийн гишүүд

С.Хулан	Дарга	2025.07.01
Ж.Ариунгэрэл	Гишүүн	2025.07.01
Д.Ганзориг	Гишүүн	2025.07.01

### ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ АЖИЛЛАСАН БАЙДЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг нийцүүлэх, хамгаалах чиг үүргийн хүрээнд зөвлөмж гаргаж холбогдох этгээдэд хүргүүлэн ажиллалаа.

Хяналтын зөвлөл нь 2025 онд нийт 12 удаа хуралдсан. Хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигч иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг хэлэлцэн хуралдаж, холбогдох зөвлөмжийг гаргасан. Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүсэлт гаргагчид хүргүүлсэн.

#### 2025 онд 12 удаа хуралдаж:

- 6 зөвлөмж
- 1 дүгнэлт
- 1 санал
- 1 хүсэлт


Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчтэй 1 удаа уулзалт зохион байгуулж, компанийн үйл ажиллагаа, засаглал, дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл авсан.

Мөн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч болон удирдах албан тушаалтнуудтай хамтарсан уулзалтыг 1 удаа зохион байгуулж, компанийн засаглал, үйл ажиллагааны зорилт, байгууллагын мэдээллийн технологийн шинэчлэлтийн бодлого болон хэрэгжилтийн талаар хэлэлцсэн.

Хяналтын зөвлөл нь 2025 онд Захиргаа, санхүүгийн газраас 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн мэдээлэл, тайлбар, тодруулга авч компанийн 2024 оны тайланг дүгнэн хувьцаа эзэмшигчийн тэргүүн зорилго болох хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах зэрэг саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж ажиллалаа.

Хяналтын зөвлөл жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлтэй 2 удаа, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчтэй 1 удаа тус тус уулзалт зохион байгуулж компанийн засаглал үйл ажиллагааны ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх байдлаар санал солилцсон.

## Танилцах асуудал - Бүтэц зохион байгуулалт



### → ХҮНИЙ НӨӨЦ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2025 оны эцэст нийт 61 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.



40

Нийт эмэгтэй ажилтан

61

Нийт ажилтан



21

Нийт эрэгтэй ажилтан



21

Үндсэн үйл ажиллагаа



40

Дэмжих үйл ажиллагааны мэргэжилтнүүд



35

Дундаж нас



7.4  
ЖИЛ

Ажилласан



18

Удаагийн сургалт

## → КОМПАНИЙН УДИРДЛАГА



**Д.Мөнхбат**  
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч



**Т.Хаш-Эрдэнэ**  
Бизнес, Хөгжлийн газар



**И.Жавхлан**  
Үйл ажиллагааны газар



**А.Мөнхбаясгалан**  
Хяналт, Зохицуулалтын газар



**Х.Эрдэнэбүрэн**  
Захиргаа, Санхүүгийн газар

## 2025 оны онцлох үйл явдлууд

2025

"Гишүүнчлэлийн журам"-ын шинэчилсэн найруулга, Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны журам, Бүртгэлийн журам, Арилжааны журмын нэмэлт өөрчлөлтийг батламжиллаа.

2025.04.02

Олон улсын стандартад нийцсэн дата төвийг ашиглалтад оруулж, bond.mse.mn платформийг нэвтрүүлээ

2025.04.16

Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжаа эхэллээ.



2025.04.23

Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн төвийг нээлээ.

2025

"Хаан Банк" ХК нь FTSE Russell-ийн Frontier Market индексэд багтсан Монголын анхны компани болсон бөгөөд Жендэр бондыг зах зээлд амжилттай нэвтрүүлээ.

2025.06.24

Хадгаламжийн сертификатыг бүртгэх журмыг батламжиллаа.

2025

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны гол үзүүлэлтүүд түүхэн дээд түвшинд хүрлээ


2025

Ногоон, тогтвортой санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэх, байгаль орчин нийгэм засаглалын тайлагналыг сайжрууллаа




## Танилцах асуудал - 2025 оны санхүүгийн гол үзүүлэлтүүд


### Нийт орлого



### Нийт зардал




### Үнэт цаасны арилжааны шимтгэл




### Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэл




### Төсөвт төлсөн татвар, шимтгэл




### Зардал, орлогын харьцаа



### Татварын дараах цэвэр ашиг



### Хуримтлагдсан ашиг





# САНХҮҮГИЙН ТАЙЛАН - 2025

1. Үндэсний аудитын газрын Аудитын дүгнэлт
2. Хараат бус аудиторын дүгнэлт
3. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн товч тайлан

*/Дэлгэрэнгүй тайланг МХБ-н 2025 оны жилийн тайлангаас үзнэ үү/*



ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР



Grant Thornton Mongolia



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/53/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn  
Аудитор: Т.Баасанцэнд  
Утас: 261885 Цахим хаяг: Baasantsendt@audit.gov.mn  
Грант торнтон аудит ХХК-ийн Гүйцэтгэх  
захирал: О.Идшинринжин  
Утас: 99993795 Цахим хаяг: info@mn.gt.com

Улаанбаатар хот  
2026 он



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.МӨНХБАТ ТАНАА

2026.03.16 № 06/674  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Хөрөнгийн Бирж ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж болон хуулийн этгээдүүд нь Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор журмын дагуу нийт 1,199,250.6 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 991,174.9 сая төгрөгийн дэнчин битүүмжлэгдсэн, 208,075.7 сая төгрөгийн идэвхтэй дэнчин Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн харилцах дансанд байна.

### Аудитын гол асуудал

Барилгын дотоод зохион байгуулалтын зураг, төсвийн дагуу оффисын тохижилтод болон мэдээлэл, үйлчилгээний нээлттэй төвийн дагалдах эд хогшилд 40 нэр төрлийн тавилга, эд хогшил худалдан авахаас 216.1 сая төгрөгийг төсөвлөсөн боловч 1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газраас төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хөрөнгийг үр ашигтай зарцуулах, тэвчиж болох зардлыг хэмнэх, зарим хөрөнгө оруулалтыг хасах, эрэмбэлэн ажиллах чиглэл ирүүлсэнтэй холбоотой гүйцэтгэл хийгдээгүй байна.

Z:\Yawsan\_Bchig\2026\0316 SAG-31.Docx

1526141067

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (IASB) 2024 онд баталсан IFRS 18 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга" стандарт нь 2027 оноос хэрэгжиж эхлэх бөгөөд өмнөх IAS 1-ийг орлож, санхүүгийн тайланг илүү ойлгомжтой, нэг загвартай, хөрөнгө оруулагчдад хэрэгцээтэй мэдээлэл өгөх зорилготой тул үүнтэй холбоотойгоор компани дараах зүйлсийг урьдчилан бэлтгэх шаардлага байна. Үүнд:

- Шинэ тайлангийн бүтэц, ангилалд нийцүүлэхийн тулд мэдээллийн систем, дансны төлөвлөгөө, бүртгэлийн зохион байгуулалт, дотоод процесс, журмуудаа хянаж шаардлагатай өөрчлөлтийг хийж, дансны ангилал, мэдээллийн урсгал, автоматжуулалтын тохиргоо болон дотоод хяналтыг шинэ шаардлагад нийцүүлэх;
- Үйл ажиллагааны түвшний шинэ ангилалуудыг ашиглах болсонтой холбоотой одоо ашиглаж буй гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарах эсэхийг үнэлж, зээлийн гэрээний шалгуур, нөхцөл, менежментийн урамшууллын тооцоололд нөлөөлөх эрсдэлийг урьдчилан тооцох;
- Стандартын нөлөөг бодитоор үнэлж, хэрэгжилтийн бэлтгэлийг үе шаттайгаар ханган, шинэ тайлангийн бүтэц болон удирдлагын ашигладаг гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн (MPM) талаарх мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх юм.

### Бусад асуудлын хэсэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хянаж баталгаажуулсан Компанийн 2024 оны засаглалын кодекс-ийн хэрэгжилтийн тайлангийн дүгнэлт нь 100 хувь, хэвийн буюу эрсдэлгүй гэж заасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Z:\Yawsan\_Bichig\2026\0316 SAG-31 Docx

# Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

## Монголын хөрөнгийн бирж ХК

2025 оны 12 дугаар сарын 31





# Хараат бус аудиторын дүгнэлт

"Грант Торнтон аудит" ХХК  
Далай тауэр, ЮНЕСКО-гийн  
гудамж, Сүхбаатар дүүрэг-1,  
Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 97670 110799

Grant Thornton Audit LLC  
Dalai Tower, UNESCO street,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230, Mongolia  
T + 97670 110799

## "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Монголын Хөрөнгийн Бирж" ХК (цаашид "компани" эсвэл "байгууллага" эсвэл "МХБ" гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангууд (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Материаллаг гол бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (цаашид "НББОУСЗ" гэх)-ийн гаргасан СТОУС Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.


### Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

### Аудитын гол асуудалууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм.

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх дуусгавар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар аудитын гол асуудал тодорхойлоогүй болно.



### *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайланг энэхүү аудиторын тайлан гарсны дараа олж авахаар тооцсон.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгхариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

### *Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхыг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар*

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзэл хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторовн тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид компанийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

### Аудитын тайлангийн хэрэглээ

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторовн тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторовн тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторовн тайландаа тодорхойлдог.

Энэхүү Хараат бус аудиторовн тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Б.Дэлгэрмаа болно.

  
**О.ИДШИНРИНЖИН**  
**УДИРДАХ ПАРТНЕР**  
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 27

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр болох 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөр хүчин төгөлдөр байна. Аудитын тайлангийн өдрөөс хойш гарсан аливаа үйл явдал, нөхцөл байдлыг бид энэхүү санхүүгийн тайлан болон түүнд хийсэн тодруулгад тусгаагүй бөгөөд аудитын тайлангийн өдрөөс хойших үйл явдлыг хянах үүрэг бидэнд байхгүй. Иймд энэхүү тайланг ашиглахдаа тайлангийн өдрөөс хойших нөхцөл байдлын боломжит нөлөөллийг өөрсдөө авч үзнэ үү.

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд  
(өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	1,203,493,791	816,117,554
Дансны болон бусад авлага	8	4,938,399	3,119,541
Бусад санхүүгийн хөрөнгө	9	50,781,268	-
Бараа материал	10	51,334	47,312
Урьдчилж төлсөн зардал/гооцоо	11	262,725	30,693
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>1,259,527,517</b>	<b>819,315,100</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө, цэвэр	12	8,778,595	7,328,148
Биет бус хөрөнгө, цэвэр	13	16,474,042	17,044,541
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>25,252,637</b>	<b>24,372,689</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>1,284,780,154</b>	<b>843,687,789</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	14	973,415	333,534
Урьдчилж орсон орлого	15	26,802	109,442
Биржийн дэнчин /УУБ/	16	1,192,815,216	767,771,157
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>1,193,815,433</b>	<b>768,214,133</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр	17	960,250	928,380
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>960,250</b>	<b>928,380</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>1,194,775,683</b>	<b>769,142,513</b>

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд  
(өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	18.1	35,046,354	35,046,354
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	446,322
Дахин үнэлгээний нэмэгдэл	18.2	19,987,925	20,005,436
Хуримтлагдсан ашиг	18.3	32,752,910	17,724,770
Биржийн эрсдэлийн сан	18.4	2,217,282	1,322,394
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>90,004,471</b>	<b>74,545,276</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b>1,284,780,154</b>	<b>843,687,789</b>

Хуудас 13–45-д харуулсан тодруулгууд нь энэхүү Санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд  
(өвөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 он	2024 он
Үйлчилгээний орлого	19	10,744,739	13,521,664
Үйлчилгээний өртөг	20	(5,876,432)	(5,166,647)
<b>Нийт ашиг</b>		<b>4,868,307</b>	<b>8,355,017</b>
Хүүгийн орлого	21	34,641,946	33,116,453
Бусад орлого	22.1	40,238	23,650
Борлуулалт, маркетингийн зардал	23	(748,992)	(671,208)
Ерөнхий ба удирдлагын зардал	24	(3,223,214)	(2,624,905)
Бусад зардал	22.2	(430,171)	(123,399)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	25	241,584	(99,547)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	(197)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>35,389,698</b>	<b>37,975,864</b>
Орлогын татварын зардал	26	(3,568,300)	(3,799,182)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>31,821,398</b>	<b>34,176,682</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Дараа үед ашиг, алдагдалд дахин ангилах зүйлс		119,730	2,135
<b>Бусад дэлгэрэнгүй орлого (зардал)-ын дүн</b>		<b>119,730</b>	<b>2,135</b>
<b>Орлогын нийт дүн</b>		<b>31,941,128</b>	<b>34,178,817</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (төгрөгөөр)</b>		<b>90.8</b>	<b>97.5</b>

Хуудас 13-45-д харуулсан тодруулгууд нь энэхүү Орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
 2025 оны 12 сарын 31-нээр дуусгаар болсон жилийн хувьд  
 (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Биржийн эрсдлийн сан	Нийт өмч
<b>2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>		<b>35,046,354</b>	<b>20,005,436</b>	<b>446,322</b>	<b>17,724,770</b>	<b>1,322,394</b>	<b>74,545,276</b>
	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	31,821,398	-	31,821,398
	Зарласан ногдол ашиг	-	-	-	(16,471,786)	-	(16,471,786)
	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	107,759	-	-	-	107,759
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(125,270)	-	125,270	-	-
	Биржийн эрсдэлийн сангийн нэмэгдэл	-	-	(446,322)	(446,742)	894,888	1,824
		-	-	-	-	-	-
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>35,046,354</b>	<b>19,987,925</b>	<b>-</b>	<b>32,752,910</b>	<b>2,217,282</b>	<b>90,004,471</b>
<b>2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>		<b>35,046,354</b>	<b>20,021,146</b>	<b>446,322</b>	<b>(11,434,011)</b>	<b>635,863</b>	<b>44,079,811</b>
	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	34,176,682	-	34,176,682
	Зарласан ногдол ашиг	-	-	-	(4,349,253)	-	(4,349,253)
	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	17,845	-	17,845
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(15,710)	-	-	-	2,135
	Биржийн эрсдэлийн сангийн нэмэгдэл	-	-	-	(686,531)	686,531	-
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	-	-	-	38	-	38
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>35,046,354</b>	<b>20,005,436</b>	<b>446,322</b>	<b>17,724,770</b>	<b>1,322,394</b>	<b>74,545,276</b>

Хуудас 13-45-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд  
(өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 он	2024 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>1,286,955,170</b>	<b>2,326,735,166</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19	9,947,733	15,877,265
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	19	5,262	14,356
Хүлээн авсан хүүгийн орлого	21	33,586,245	31,119,193
Бусад мөнгөн орлого	16	1,243,415,930	2,279,724,352
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>860,176,167</b>	<b>2,410,500,738</b>
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн			
Ажиллагчдад төлсөн	23, 24	3,839,915	2,914,157
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23, 24	1,059,349	826,172
Бараа материал худалдан авахад төлсөн	10	41,904	63,965
Ашиглалтын зардалд төлсөн	23	120,874	85,682
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн	23	3,052	992
Татварын байгууллагад төлсөн	14	4,824,633	5,486,590
Даатгалын төлбөрт төлсөн	24	4,628	5,107
Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжинд төлсөн	24	543,423	806,791
Бусад мөнгөн зарлага	16	849,738,389	2,400,311,282
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>426,779,003</b>	<b>(83,765,572)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>4,715,050</b>	<b>4,500</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	12	-	4,500
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	22.1	4,715,050	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>58,346,302</b>	<b>3,165,765</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12	2,054,403	2,343,658
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13	735,666	822,107
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13	55,556,233	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(53,631,252)</b>	<b>(3,161,265)</b>

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд  
(өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Мөнгөн гүйлгээний тайлан

## (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 он	2024 он
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>		-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>16,186,706</b>	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		-	-
Төлсөн ногдол ашиг	18.5	16,186,706	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(16,186,706)</b>	-
Валютын ханшийн зөрүү	28	30,415,191	461,576
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>387,376,236</b>	<b>(86,465,261)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>7</b>	<b>816,117,554</b>	<b>902,582,815</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7</b>	<b>1,203,493,791</b>	<b>816,117,554</b>

Хуудас 13-45-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

## Хэлэлцэх асуудал №1



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

#### Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тус тус "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж улирал тутам тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1526010 32

## Хэлэлцэх асуудал №1 - Тогтоолын төсөл

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

№01

Улаанбаатар хот

#### Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.9 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д.ТОГТОХБАЯР**

## Хэлэлцэх асуудал №2



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

#### Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.7.27 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг 1 дүгээр хавсралтаар дэмжсүгэй.
2. Компанийн 2026 оны Бизнес төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Энэхүү тогтоолоор баталсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал, Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчид болон зохих байгууллагад хүргүүлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

152691 001

## Хэлэлцэх асуудал №2

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2026 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛГОТ ТҮВШНИЙ САНДАЛ

Мянган төгрөг

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн  
62 дугаар тогтоолын Нэвдэвээр Хавсралт

№	Үзүүлэлтүүд	2024 оны гүйцэтгэл	2025 он		2025 оны төлөшлөгөө	2025 оны харьцуулсан өөрчлөлт хувь	Мөнгөн дүн
			Төлөвлөгөө	ХСГ			
<b>A</b>	<b>Нийт орлого:</b>	<b>46,661,767</b>	<b>42,693,290</b>	<b>43,961,929</b>	<b>46,029,944</b>	<b>5%</b>	<b>2,068,015</b>
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>13,546,314</b>	<b>11,287,282</b>	<b>9,698,262</b>	<b>13,389,945</b>	<b>38%</b>	<b>3,691,682</b>
1.1	Үндэстэй үйлдвэрлэлийн орлого	3,313,730	3,520,887	1,546,850	4,051,307	162%	2,504,457
1.2	УУББ-ийн ажиллагааны орлого	8,067,909	6,008,888	6,248,219	6,973,503	12%	725,285
1.3	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	1,975,758	1,625,597	1,793,788	2,290,679	28%	496,891
1.5	Бусад	187,916	131,909	109,406	74,455	-32%	-34,951
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны бус орлого</b>	<b>33,116,454</b>	<b>31,406,008</b>	<b>34,263,667</b>	<b>32,640,000</b>	<b>-5%</b>	<b>-1,623,667</b>
2.1	Хувьцаа орлого	33,116,454	31,406,008	34,263,667	32,640,000	-5%	-1,623,667
<b>Б</b>	<b>Нийт зардал:</b>	<b>8,586,159</b>	<b>11,211,579</b>	<b>10,714,304</b>	<b>12,713,952</b>	<b>19%</b>	<b>1,999,647</b>
3.1	Үйл ажиллагааны зардал	5,431,590	7,107,053	6,817,914	8,270,726	21%	1,452,812
3.2	Урсгал зардал	813,628	1,288,805	1,265,140	1,660,563	31%	395,423
3.3	Мэдээлэл технологийн зардал	1,795,492	2,039,757	1,983,296	1,955,139	-1%	-28,157
3.4	Үйл ажиллагааны дэмжигч зардал	250,362	363,601	126,936	394,567	211%	267,631
3.5	Үйл ажиллагааны бус зардал	295,087	412,364	521,018	432,956	-17%	-88,062
<b>B</b>	<b>Татварын өмнөх цэвэр орлого (алдагдал)</b>	<b>37,975,865</b>	<b>31,277,293</b>	<b>33,043,208</b>	<b>33,110,993</b>	<b>0.2%</b>	<b>67,765</b>
4.1	Орлогын, хүүгийн орлогын татвар	3,799,182	3,148,171	3,324,762	3,331,599	0%	6,837
<b>5</b>	<b>Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>34,176,683</b>	<b>28,129,122</b>	<b>29,718,445</b>	<b>29,779,393</b>	<b>0.2%</b>	<b>60,948</b>
6	Нийт авлага (цэвэр)	3,150,234	201,900	3,407,505	3,238,365	-5%	-169,139
7	Нийт өглөг (системийн зардал оруулж тооцсонор)	2,007,250	807,752	1,073,427	802,500	-25%	-270,927
8	УУББ-ийн ажиллагааны дэнчингийн мөнгө	767,771,157	893,556,358	1,061,982,150	967,870,045		
9	Ажиллагсдын тоо	65	72	61	72		11
10	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.18	0.26	0.24	0.28		0.03
11	Хөрөнө оруулалт	994,663	1,473,120	1,106,184	1,374,426	24%	268,242

## Хэлэлцэх асуудал №2 - Тогтоолын төсөл

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

№02

Улаанбаатар хот

#### “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.14 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д тус тус даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д.ТОГТОХБАЯР**

## Хэлэлцэх асуудал №3



**Д.Тогтохбаяр**  
Ердийн гишүүнд  
нэр дэвшигч

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

#### Боловсрол

- 2003-2007 ШУТИС-Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль Санхүү менежмент - Бакалавр
- 2011-2013 Удирдлагын академи Төрийн удирдлагын магистр - Магистр

#### Ажил эрхлэлт

- 2007-2011 Монголын хөрөнгийн бирж ТӨХК Бүртгэл хяналтын алба гишүүн компани хариуцсан мэргэжилтэн
- 2011-2014 Монголын хөрөнгийн бирж ТӨХК Бүртгэл хяналтын алба гишүүн компани хариуцсан ахлах мэргэжилтэн
- 2015-2016 Монголын хөрөнгийн бирж ТӨХК Хяналт зохицуулалтын газрын захирал
- 2016-2018 Монголын хөрөнгийн бирж ТӨХК Арилжааны албаны захирал
- 2019-2022 Монголын хөрөнгийн бирж ТӨХК Бүртгэлийн албаны захирал, ахлах мэргэжилтэн
- 2022-Одоо МУБИС Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга
- 2023-Одоо Монголын хөрөнгийн бирж ХК ТУЗ-ийн дарга



**М.Банзрагч**  
Ердийн гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 2000-2004 ХУДС - Эдийн засагч - Бакалавр
- 2004-2006 МУИС - Хэрэглээний математик - Магистр
- 2010-2014 ШУТИС - Бизнесийн удирдлага - Доктор

#### Ажил эрхлэлт

- 2004-2007 ШУТИС - Компьютерийн техник менежментийн сургууль, эконометрийн үйлдлийн судалгааны профессорын багт туслах багш
- 2007-2012 ШУТИС - Компьютерийн техник менежментийн сургууль, эконометрийн үйлдлийн судалгааны профессорын багт багш
- 2012-2014 ШУТИС - Компьютерийн техник менежментийн сургууль, эконометрийн үйлдлийн судалгааны профессорын багт ахлах багш
- 2014-2015 ШУТИС - Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, математикийн тэнхимийн ахлах багш
- 2015-2017 ШУТИС - Бизнесийн ахисан түвшний сургууль Ахлах багш
- 2015-2019 ШУТИС - Бизнесийн ахисан түвшний сургууль Дэд профессор
- 2019-2022 ШУТИС - Бизнесийн ахисан түвшний сургууль Дэд захирал
- 2022-2025 ШУТИС - Бизнесийн ахисан түвшний сургууль Дэд профессор, сургалт чанарын албаны дарга
- 2025-Одоо ШУТИС - Бизнесийн ахисан түвшний сургууль Сургалт чанарын албаны дарга

## Хэлэлцэх асуудал №3



**Ж.Цогтбаяр**  
Ердийн гишүүнд  
нэр дэвшигч

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

#### Боловсрол

1988-1992	Харьков хотын цэргийн сургууль Эдийн Засагч - Бакалавр
1992-1994	МУИС - Санхүүч эдийн засагч - Бакалавр
1996-1998	Төрийн захиргааны удирдлагын хөгжлийн институт Төрийн захиргааны менежер - Бакалавр
2001-2002	Удирдлагын академи - Төрийн удирдлагын магистр
2005-2008	АНУ Виржиниа ОУ-ийн их сургууль - Бизнесийн удирдлага - магистр

#### Ажил эрхлэлт

1994-2000	Сангийн яам - Санхүүгийн хяналт шалгалтын албанд Улсын байцаагч
2000-2002	Санхүүгийн хяналт шалгалтын газар - Даатгалын хяналтын албаны дарга
2003-2008	Улсын мэргэжлийн хяналтын газар - Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэсийн дарга
2008-2009	Улсын мэргэжлийн хяналтын газар - Санхүү аж ахуйн хэлтэсийн дарга
2009-2014	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэсийн дарга
2014-2024	Сангийн яам - Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэсийн дарга
2024-2025	Монголын хөрөнгийн бирж ХК - Удирдлага ГЗУТОГ
2025-2025	Сангийн яам - Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэсийн дарга
2025-Одоо	Сангийн яам - Дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтын үнэлгээний газрын дарга



**Т.Ганбаатар**  
Ердийн гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

2000-2005	Эрхүү ЧС - Эрх зүйч - Бакалавр
2002-2003	Эрхүү ЧС - Орчуулагч - Бакалавр
2000-2005	Эрхүү ЧС - Эрх зүйч - Магистр

#### Ажил эрхлэлт

2005-2007	ХЗДХЯ ХТС Шинжээч
2007-2012	ХЗДХЯ ХЗБГ Мэргэжилтэн
2012-2017	ХЗЯ ХЗИБГ Хэлтэс, газрын дарга
2017-2021	МХХ МХХороо Ажлын албаны дарга
2021-2022	МХЕГ Хуулийн газрын дарга
2022- Одоо	АҮЭБЯ Хуулийн хэлтсийн дарга

## Хэлэлцэх асуудал №3



**Ж.Бямбасүрэн**  
Ердийн гишүүнд  
нэр дэвшигч

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

#### Боловсрол

- 1983-1985** Санхүү эдийн засгийн техникум - Санхүү эдийн засагч - Дээд
- 1997-1999** СЭЗДС - Нягтлан бодогч, эдийн засагч - Бакалавр
- 1999-2000** Удирдлагын академи - ТУ-ийн арга зүй, зохион байгуулалт мэргэжил менежер цол - Цол
- 2004-2006** Удирдлагын академи - Төрийн захиргааны удирдлагын менежер - Магистр

#### Ажил эрхлэлт

- 1985-1987** Баян-уул амралтын захиргаа - Тооцооны нягтлан бодогч
- 1987-1988** Октябрийн районы, Ахуй үйлчилгээний төв - Касс тооцоо гаргагч
- 1988-1990** Сүхбаатар аймгийн Эрүүлийг хамгаалах газар- Санхүүгийн хэлтэс Тооцооны нягтлан бодогч
- 1994-2002** Сонгино-Хайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар - Санхүүгийн хэлтэс Ахлах нягтлан бодогч
- 2002-2006** Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар /хуучин нэрээр/ - Тамгын хэлтэс - Санхүүгийн хяналтын байцаагч, хяналт шинжилгээний үнэлгээний мэргэжилтэн
- 2006-2012** Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар /хуучин нэрээр/ - Санхүү эдийн засгийн хэлтэс Ахлах мэргэжилтэн
- 2012-2012** Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар - Хэлтэсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч
- 2012-2013** Засгийн газрын хэрэг эрхлэх газар - Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтэс - Ерөнхий санхүүч
- 2013-2020** Засгийн газрын хэрэг эрхлэх газар - Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтэсийн дарга, ерөнхий санхүүч
- 2020-Одоо** Засгийн газрын хэрэг эрхлэх газар - Санхүү эдийн засгийн газрын дарга



**Н.Отгончимэг**  
Хараат бус  
Гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 1986-1988** Санхүү эдийн засгийн техникум - Статистикч эдийн засагч
- 1999-2003** Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль - Бизнесийн удирдлага

#### Ажил эрхлэлт

- 1988-2020** ХШШГЕГ Анги салбар Ерөнхий нягтлан бодогч
- 2020-2021** ШШГЕГ Санхүү эдийн засаг хөрөнгө оруулалт Хэлтэсийн дарга
- 2021-2022** ШШГЕГ Амралт сувилал Дарга
- 2022-2022** Саамын индустриал Санхүү Санхүүч
- 2022-2023** Сүлд Аудит ХХК Аудитор
- 2024-Одоо** "Гурван хөх морьт аудит" ХХК Гүйцэтгэх захирал

## Хэлэлцэх асуудал №3

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.



**Р.Мөнхтөр**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 1997-2001 МУИС Эдийн засагч багш - Бакалавр  
2001-2003 МУИС Эдийн засгийн ухаан - Магистр

#### Ажил эрхлэлт

- 2001-2003 Сэрүүлэг ДС Математикийн тэнхим - Багш  
2003-2004 ХУДС Математикийн тэнхим - Багш  
2003-2005 ШУТИС ХБТС КТМС - Багш  
2005-2016 МУИС ЭЭС - Багш  
2011-2016 МУХБ ТУЗ СБТГ - Нарийн бичиг  
2016-2019 Инвескор ББСБ - Дэд захирал  
2020-2023 Sib capital - Дэд захирал  
2020-2023 МУХБ - ТУЗ гишүүн  
2023-Одоо Монголын Хөрөнгийн бирж ХК - ТУЗ хараат бус гишүүн  
2024-Одоо "Айкор партнерс" ХХК - Дэд захирал



**Х.Булгантамир**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 2007-2010 Seattle Central Collage - Бизнесийн удирдлага - Дэд Бакалавр  
2010-2012 University of Minnesota - Эрчим хүчний санхүүжилт ба байгаль орчны бодлого - Бакалавр  
2020-2022 Columbia University - Санхүү ба хөрөнгө оруулалт - Магистр

#### Ажил эрхлэлт

- 2010-2012 Carison Funds Enterprise - Fixed income - Үнэт цаасны шинжээч  
2012-2012 RBC Golbal Asset Management - Fixed income - Үнэт цаасны шинжээч  
2013-2016 Эрдэнэс Таван толгой ХК - Хөрөнгө оруулалтын хэлтэс  
Ахлах шинжээч, хөрөнгө оруулалтын хэлтэсийн захирал  
2016-2019 Голомт банк - Хөрөнгө оруулалтын банкны хэлтэс, төслийн санхүүжилтийн хэлтэс  
Ахлах шинжээч, хэлтэсийн захирал  
2021-2022 Morgan Stanley - Private Credit and equity - Тогтвортой санхүүжилтийн зөвлөх  
2023-2025 Arcadis - Тогтвортой хөгжлийн зөвлөх үйлчилгээ - Менежментийн зөвлөх  
2025-Одоо НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр - МУ-д нүүрс төрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл Төслийн үндэсний зохицуулагч

## Хэлэлцэх асуудал №3

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.



**Б.Эрдэнэсанаа**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

### Боловсрол

- 1987-1991 УАААДС - Банк зээлийн эдийн засагч - Бакалавр
- 1997-1998 Рочестерийн их сургууль - Бизнесийн удирдлагын магистр - Магистр

### Ажил эрхлэлт

- 1991-1995 ХХБанк - КЗҮХГ - Дэд захирал
- 1995-1999 ХХБанк - КЧГ - Захирал
- 2000-2004 Инвесско ХХК - Инвесском ББСБ - Захирал
- 2004-2007 ХХБ - Иргэдийн банк - Дэд ерөнхийлөгч
- 2007-2008 Gerald Metals, INC - Merchant banker
- 2009-2017 Сфеко ХХК - Захирал
- 2017-2019 ЗГХЭГазар - Даргын зөвлөх
- 2020-Одоо Бүрэн скор ЗМС ХХК - Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн



**М.Өлзийсайхан**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

### Боловсрол

- 1985-1990 МУИС - Эдийн засагч, Статистикч - Бакалавр
- 1998-1999 МУИС - Эдийн засгийн ухааны магистр

### Ажил эрхлэлт

- 1995-1996 "Газар трейд" ХХК - Захиргаа Дэд захирал
- 1997-1999 "Жамп" ХХК Захиргаа Дэд захирал
- 1999-2001 "Гигант" ХХК Захиргаа Захирал
- 2001-2004 "Арцат богд" ХХК Захиргаа Ерөнхий захирал
- 2004-2006 "Глори импекс" ХХК Захиргаа Захирал
- 2006-2010 "Аж трейд" ХХК Захиргаа Гүйцэтгэх захирал
- 2010-2010 "Олон овоот голд" ХХК - Төлөөлөгчийн газрын дарга
- 2010-2022 "Ананд холдинг" ХХК - Ерөнхий захирал
- 2020-2023 Хүний хөгжил судалгаа сургалтын төв - Зөвлөх
- 2024-2024 Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв - Төсөл боловсруулах хэлтэс - Мэргэжилтэн
- 2024-2025 Шадар сайдын ажлын алба - ШХХСДУХ үндэсний хороо - Ахлах мэргэжилтэн
- 2025-Одоо "Эрчист Монгол" ТӨХХК - ТУЗ-ийн ажлын алба - Мэргэжилтэн

## Хэлэлцэх асуудал №3

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.



**Н.Туул**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 1986-1990** МУ Нийгмийн ухааны факультет - Түүхч, түүхийн багш - Бакалавр
- 1997-2000** МУИС Хууль зүйн сургууль - Эрх зүйч - Бакалавр
- 2008-2010** Удирдлагын академи - Төрийн удирдлагын менежер - Бакалавр
- 2012-2014** Удирдлагын академи - Төрийн удирдлага - Магистр

#### Ажил эрхлэлт

- 1991-1995** Нийслэлийн 15-р сургууль - Түүх-нийгмийн ухааны багш
- 1996-1997** "Толь" сонины газар - Санхүү бүртгэлийн хэсэг - Борлуулалт хариуцсан ажилтан
- 1998-2000** Нийслэлийн архивын газар - Сан хөмрөгийн эрхлэгч, ахлах мэргэжилтэн
- 2000-2006** Үндэсний архивын газар - Тамгын хэлтэс, Бодлого зохицуулалт, хяналтын хэлтэс  
Тамгын хэлтэсийн дарга, архив албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч
- 2006-2015** Санхүүгийн зохицуулах хороо Дотоод хяналтын алба Тамгын газар  
Мэргэжилтэн Албаны дарга, Хэлтэсийн дарга
- 2016-2018** "Төрийн банк" ХХК - Сүхбаатар дүүрэг салбарын захирал
- 2018-2019** "Эрдэнэс Таван толгой" ХК - Гэрээ эрх зүйн хэлтэс - Хуульч, Ахлах хуульч Хэлтэсийн дарга
- 2019-2020** "Эрдэнэс Таван толгой Майнинг" ХХК - Эрх зүйн хэлтэс - Хуульч, Хэлтэсийн менежер
- 2020-2025** Нийслэлийн архивын газар - Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Газрын дарга
- 2024-Одоо** "Монголын цахилгаан холбоо" ХК - ТУЗ - Хараат бус гишүүн



**Ч.Энхбаяр**  
Хараат бус  
гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 1982-1988** УАААДС - Санхүү зээлийн эдийн засагч Бакалавр, Магистир
- 1999-2002** Эдийн засгийн улсын академи - Эдийн засгийн ухааны доктор

#### Ажил эрхлэлт

- 1991-1998** БГД татварын хэлтэс - Татвар хураалтын тасаг - Татварын улсын байцаагч
- 2002-2003** Татварын ерөнхий газар - Сургалт үйлчилгээний төв - ТУБ-багш
- 2003-2009** МУИС ЭЗС - Дэд профессор
- 2009-2013** МУИС ЭЗС - Тэнхимийн эрхлэгч
- 2014-2017** МУИС Бизнесийн сургууль - Профессор
- 2017-2023** МУИС Бизнесийн сургууль - Захирал
- 2023-2024** МУИС Захиргаа Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор
- 2024-Одоо** МУИС Бизнесийн сургууль - Профессор

## Хэлэлцэх асуудал №3

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.



**Т.Очирхүү**  
Хараат бус  
Гишүүнд  
нэр дэвшигч

#### Боловсрол

- 1997-2001** МУИС - Эдийн засагч - Бакалавр
- 2011-2013** Манчестерийн их сургууль - Эдийн засагч - Магистр
- 2017-2026** Бээжингийн их сургууль Олон улсын бизнес, эдийн засгийн сургууль - Эдийн засагч - Докторант

#### Ажил эрхлэлт

- 2001-2002** Хүүхэд залуучуудын хөгжлийн төв - Нябо
- 2002-2004** Хас банк Төв салбар - Теллер, мэргэжилтэн
- 2004-2007** Анод банк - Эрсдэлийн газар Эдийн засагч, менежер
- 2007-2007** Эм Си Эс Гоёо ХХК - Санхүү бүртгэлийн газрын дарга
- 2007-2011** Эрин интернейшнэл ХХК - Дэд захирал
- 2013-2017** Хөгжлийн банк - Зээлийн эрсдлийн захирал
- 2019-2020** Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК - Дэд захирал
- 2021-2021** Төрийн худалдан авах ажиллагааны газар, Азийн хөгжлийн банк - "Худалдан авалтын ерөнхий гэрээ" төслийн үндэсний зөвлөх
- 2021-2022** Говь каол Энерги ХХК - "Нүүс олборлолт тээвэрлэлт, төмөр зам" төслийн захирал
- 2022-2022** Нийслэлийн засаг даргын тамгын газар, НҮБ хөгжлийн хөтөлбөр - "Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг ТХХТ барих" төслийн үндэсний зөвлөх
- 2022-2025** Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк - "Жендерийн мэдрэмжтэй бичил ногоон санхүүжилт" төслийн үндэсний зөвлөх
- 2023-2023** Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК - Санхүү, хөрөнгө оруулалтын газрын захирал
- 2024-2024** Боловсролын яам, Азийн хөгжлийн банк - "Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн үндэсний зохицуулагч
- 2024-2024** Коммодити трейд маркетс ХХК - Арилжааны газрын захирал
- 2025-Одоо** Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Азийн хөгжлийн банк - "Төрийн өмчит компанийн шинэчлэл" төслийн үндэсний зөвлөх
- 2026-Одоо** Улаанбаатар смарт карт ХХК - ТУЗ -ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга

## Хэлэлцэх асуудал №3 - Тогтоолын төсөл

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

№03

Улаанбаатар хот

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.7 дахь хэсэг, 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлсүгэй.
1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 3 жилийн хугацаагаар сонгосугай.
  - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
    - 1) ...
    - 2) ...
    - 3) ...
    - 4) ...
    - 5) ...
  - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
    - 1) ...
    - 2) ...
    - 3) ...
    - 4) ...
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолд заасан хэмжээгээр, тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга(Г.Тэмүүжин)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.ТОГТОХБЯЯР

## Саналын хуудасны загвар

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 03 сарын 18-ны өдрийн 09 дүгээр  
тогтоолын Дөрөвдүгээр хавсралт

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Регистрийн дугаар/ИБД: .....

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн тоо: .....

Бүртгэсэн / Үнэт цаасны компани / .....

Брокерын овог: ..... нэр: .....

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах Монголын хөрөнгийн биржийн төв байрны 1 давхарт байрлах хурлын танхимд болно.

**Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.**

**Саналын хуудас бөглөх заавар:** Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг ✓ тэмдэглэж санал болгоны ард гарын үсгээ зурна.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах;	Ердийн	Тогтоол №1	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
2	Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;		Тогтоол №2	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

## Саналын хуудасны загвар

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.

<b>ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:</b>			
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох			
ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо	Гарын үсэг
1	Тогтоол №3		
2			
3			
4			
5			
ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо	
6	Тогтоол №3		
7			
8			
9			
10			
11			
12			
13			

Саналын хуудсыг бүртгэж, хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:  
 ..... / / 2026 оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдөр

## Санал авах хуудсыг бөглөх санамж

### Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

1. Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаяг байрлах Монголын хөрөнгийн биржийн байр, цахим хэлбэрээр өгөх бол Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар өгч болно.
2. Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
4. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:
  - 4.1. Та саналын хуудсыг бөглөхдөө тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл **+ тэмдгээр саналаа өгнө.**
  - 4.2. **Засварласан, балласан эсвэл аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.**
5. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:
  - 5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд өгөх саналыг кумулятив аргаар хураана.
  - 5.2. Хувьцааны нэгж тутамд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох 1 саналын эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч нь А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

*Энэ хэсгийг Тооллогын комисс бөглөнө.*

Хэлэлцэх асуудал № ....., ....., ....., ..... саналыг **хүчинтэйд** тооцов.

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:...../ /

Хэлэлцэх асуудал № ....., ....., ....., ..... саналыг **хүчингүйд** тооцсон шалтгаан:  
.....



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

Монголын Хөрөнгийн Бирж  
Сүхбаатарын талбай-3,  
Улаанбаатар 15160, Монгол улс

**Утас:** (+976)-11-313747  
**Факс:** (+976)-11-325170  
**Веб хуудас:** [www.mse.mn](http://www.mse.mn)  
**И-мэйл:** [info@mse.mn](mailto:info@mse.mn)



ШУДАРГА ЕС,  
ХӨГЖИЛ  
ДЭВШИЛД



11-10

АВЛИГА МЭДЭЭЛЭХ УТАС  
ЯРИАНЫ ТӨЛБӨРГҮЙ